

“Дархан нэхий” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны дугаар сарын өдрийн
..... тоот тогтоолын хавсралт №.....



“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН НОГДОЛ АШИГИЙН ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү ногдол ашгийн журам /Цаашид “Журам” гэх/-ын зорилго нь “Дархан нэхий” ХК /Цаашид “Компани” гэх/-ийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг болох бөгөөд ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү журам нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн дүрэм болон зохицуулах байгууллагаас гаргасан бусад холбогдох дүрэм, журмуудад нийцсэн байх бөгөөд Компанийн ногдол ашиг хуваарилах, төлөх ажиллагаа нь тэдгээрийг мөрдлөг болгоно.
- 1.3 Журам нь компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл /Цаашид “ТУЗ” гэх/ баталснаар хүчин төгөлдөр үйлчилнэ.


ХОЁР. НОГДОЛ АШИГИЙН БОДЛОГО

- 2.1. Компани нь Хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой төвшинд байлгах бодлого баримтална.
- 2.2. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ гаргана.
- 2.3. ТУЗ шийдвэртээ хувьцаа бүрт ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.
- 2.4. Ногдол ашгийг төлөх хэлбэр болон хугацаа нь Хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн байх ба холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын журам, зөвлөмжийн дагуу байна.
- 2.5. Компанийн жилийн санхүүгийн тайлан гарсны дараа дор дурдсан нөхцөлд цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилна:
 - 2.5.1. Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
 - 2.5.2. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, энэ дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
 - 2.5.3. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.
- 2.6. Ногдол ашиг хуваарилаагүй бол ТУЗ шалтгааныг хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.
- 2.7. Компани ногдол ашгийг тогтоосон хугацаандаа бүрэн төлж дуусдаг байх бөгөөд ногдол ашиг төлөх хугацаа нь тухайн жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсан өдрөөс хойш байх ба тухайн жилдээ төлж дууссан байна.

ГУРАВ. НОГДОЛ АШИГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

- 3.1. Ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон тооцооллыг тухайн жилд ТУЗ гаргана.
- 3.2. Тооцооллыг Ерөнхий захирал санал болгож болно.

ДӨРӨВ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТӨЛӨХ

Тамгын
Холбоот

21/10

- 4.1. ТУЗ нь Компанийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн ногдол ашиг авах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тус өдрөөр тасалбар болгож “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иас Хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй хуулгыг гаргуулан авна.
- 4.2. Компани нь хувьцаанд ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хуулийн 46-47 дугаар зүйлд заасан шаардлагыг биелүүлсэн байна.
- 4.3. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрт Компанийн тухай хууль заасны дагуу дараах зүйлийг тусгана. Үүнд:
 - 4.3.1. Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ,
 - 4.3.2. Ногдол ашгийг төлөх хугацаа,
 - 4.3.3. Ногдол ашгийг төлөх хэлбэр,
 - 4.3.4. Ногдол ашиг авах эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдөр,
 - 4.3.5. Бусад асуудал,
- 4.4. Ногдол ашиг хуваарилах талаар Хувьцаа эзэмшигчдэд өдөр тутамын сонин, хэвлэл, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон компанийн цахим хаягаар мэдээлэл хүргэнэ.
- 4.5. Бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд өөрийн эзэмшилд байсан хувьцааг бусдад шилжүүлсэн тохиолдолд ногдол ашиг авах эрх нь уг хувьцааны хуучин эзэмшигч этгээдэд үлдэнэ.
- 4.6. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж дуусах хугацааны эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч байх тохиолдолд хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтлөнө.
- 4.7. Ногдол ашгийг СЗХ-ны 2020 оны 28 дугаар тогтоолын дагуу олгоно.

ТАВ. ТАЙЛАГНАХ


- 2.1. Ногдол ашигийн хуваарилалтын тайланг холбогдох журмын дагуу гаргаж, Санхүүгийн зохицуулах хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлэх бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.
- 2.2. Ногдол ашиг төлсөний дараагийн санхүүгийн улиралд Компани энэ талаар нягтлан бодох бүртгэлийн холбогдох журмын дагуу санхүүгийн тайланд үнэн зөвөөр тусгах үүрэгтэй.

ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Хууль, тогтоомж, ногдол ашиг хуваарилах, төлөх үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагын шийдвэр, дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд гэм буруутай эдгээд хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.
- 6.2. Компани ногдол ашгаа тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчийн нэхэмжлэлээр алданги төлөх бөгөөд үүнээс компанид учирсан хохирлыг тухайн компанийн Гүйцэтгэх удирдлага нөхөн төлнө.

-----oOo-----

Тамгын х.
ХЭЖС-ийн



Handwritten signature and date: 11/10